



Оюутны дадлагын хөтөлбөр

АЛСЫН ХАРАА - МАНАЙ ИРЭЭДҮЙ



Алсын хараа	Эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэнэ				
Эрхэм зорилго	Аюулгүй ажиллагааг эрхэмлэж, дэлхийд өрсөлдөхүйц зэсийн үйлдвэрлэлийг цогцлоож, Монгол Улсын хөгжил дэвшилд хувь нэмэр оруулна				
Үнэт зүйлс	Аюулгүй ажиллагаа	Хамтын зүтгэл	Хүндэтгэл	Ёс зүй	Төгөлдөршил

Тэргүүлэх чиглэл	Аюулгүй ажиллагаа 	Хамт олон 	Мөнгөн хөрөнгө 	Түншлэл 	Өсөлт 
Үндсэн зорилт	<p>Аюулгүй ажиллагаагаа улам бататгаж, салбартаа тэргүүлнэ</p> <p>Дэлхийн жишигт нийцсэн, байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаагаа хадгална</p>	<p>Чадварлаг, эвсэг хамт олныг бүрдүүлнэ</p> <p>Хөдөлмөр эрхлэх шударга, нээлттэй орчныг бэхжүүлнэ</p> <p>Авьяас, ур чадварыг үргэлжлүүлэн хөгжүүлнэ</p>	<p>Бизнесийн үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулж, үр ашгаа нэмэгдүүлнэ</p> <p>Шинийг эрэлхийлсэн, эзний сэтгэлгээтэй, бүтээлч хамт олныг төлөвшүүлнэ</p>	<p>Хамтран ажиллагч талуудтай үр ашигтай, эерэг харилцаагаа бэхжүүлнэ</p> <p>Өмнөговийн бизнес эрхлэлт, орон нутгийн бие даасан, тогтвортой хөгжлийг дэмжинэ</p> <p>Өрсөлдөх чадвартай, үндэсний ханган нийлүүлэлтийн тогтвортой сүлжээг дэмжинэ</p>	<p>Гүний уурхайн бүтээн байгуулалтыг хугацаанд нь дуусган, бүрэн хүчин чадалд нь хүргэснээр Оюу толгойн ирээдүйг баталгаажуулна</p> <p>Түншийн тогтвортой харилцааг эрхэмлэн бэхжүүлнэ</p> <p>Бүтээгдэхүүнийг зах зээлд осол аюулгүй, түргэн шуурхай хүргэх чадавх бүхий ханган нийлүүлэлтийн сүлжээг өргөжүүлнэ</p>

“Ахлах сургуулиас ажлын байр хүртэл”



Хувь хүний хөгжил болон мэргэжил эзэмших

- Оюутны сургалтын тэтгэлэг
- Говийн тэтгэлэг
- Дадлагын хөтөлбөр
- Залуусын хөгжлийн хөтөлбөр
- Ажлын туршлага
- Мэргэжлийн дадал, мэдлэг
- Багаар ажиллах, манлайлал
- Олон улсын сүлжээ



Манлайлагч ба
Мэргэжилтнүүд

Шинэ
төгсөгчид

Их
сургууль



Ахлах
сургууль

Залуусын
хөгжлийн
хөтөлбөр

Оюутны дадлагын хөтөлбөр

Оюунлаг хүмүүн Монголын баялаг



ЗОРИЛГО: Аюулгүй ажиллагааны соёл, ур чадварыг хөгжүүлж ажлын туршлага олгох

- **Шалгуур:** 2-4 дүгээр дамжааны оюутан болон ажлын туршлага олох зорилго бүхий шинэ төгсөгч
- **Хугацаа:** 1-3 сар. Дээд тал нь 6 сар хүртэл байх боломжтой.
- **Удирдамж:** Хөтөлбөрийн талаарх бодлого болон Дадлагажигч оюутны гэрээ
- **Амлалт:** Дадлага хийснээр компаний ажилтан болно гэсэн баталгаа болохгүй.
- **Үүрэг, оролцоо:** Оюутан өөрийн хөгжилд анхаарч, идэвх чармалттай ажиллах
- **Хөгжлийн төлөвлөгөө:** Удирдах ажилтан оюутны хамтаар сургуулиас олгогдсон дадлагын удирдамж болон оюутны хөгжлийн хэрэгцээнд үндэслэн хэмжигдэхүйц, бодитой “Хувийн хөгжлийн төлөвлөгөө”-г боловсруулан хэрэгжүүлнэ.
- **Хяналт:** Удирдах ажилтан оюутны гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах бөгөөд оюутны ажлын гүйцэтгэлийн тухайд уулзалт зохион байгуулж санал, зөвлөмж өгнө.
- **Үнэлгээ:** Хөтөлбөрийн төгсгөлд оюутан, ахлах ажилтан хоёул үнэлгээ өгнө.
- **Амжилт тодорхойлох:** Дадлагын хугацааны эхэнд хэрэгжүүлэхээр тохирсон төсөл, хөгжлийн төлөвлөөгөөний хэрэгжилтээр амжилтыг тодорхойлно.



ДАДЛАЖИГЧ ОЮУТНЫ ХӨТӨЛБӨР (2010-2017)



Дадлагын хөтөлбөр нь оюутнуудыг сурч буй мэргэжлийн чиглэлээрээ “Оюу толгой” компанид дадлагажин ажиллах боломжоор хангахад оршино.

Оюу Толгой компани Дадлагажигч оюутны хөтөлбөрийг 2010 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн.

НИЙТ ХАМРАГДСАН ОЮУТНУУД:

346

Оюутнууд хамрагдсан

8

Оюу толгойн гадаад тэтгэлэг авсан оюутнууд

48

Дотоодын тэтгэлэг авсан оюутнууд

34

Залуусын хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан оюутнууд

256

Бусад

ХҮЙСИЙН ХАРЬЦАА:



168



178

ДАДЛАГАЖУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙН ТӨРЛҮҮД:



Жилийн туршид үргэлжлэх дадлага



Зуны дадлага



Ажлын туршлага олгох дадлага



Үйлдвэрлэл дээр судалгаа хийх

ДАДЛАГАЖУУЛАХ ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ОЮУТНУУДААС:

51

Оюу Толгойн үндсэн ажилтан болсон

15

Шинэ төгсөгчийг хөгжүүлэх хөтөлбөрт хамрагдсан

ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДСАН ХҮҮХДИЙН ТОО (ОНООР):

70

2010

61

2011

29

2012

21

2014

21

2015

53

2016

91

2017

Дадлагын хөтөлбөрийн төрлүүд



	Жилийн турш үргэлжлэх	Оюутны амралтаар явагдах	Ажлын туршлага олгох	Үйлдвэрлэлийн судалгааны ажил
Төрөл	Оюутан хичээлийн бус цагаар өөрийн сурч буй мэргэжлийн дагуу дадлага хийж ажлын туршлага олох	Оюутан зун, өвлийн амралтаар холбогдох мэргэжлийн чиглэлээр туршлага олох	Шинэ төгсөгч оюутан мэргэжлээрээ ажиллаж ажлын туршлага олж, хувийн анкетаа хөгжүүлэх	Төгсөх дамжааны оюутан үйлдвэрлэл дээр тулгарсан бодит асуудлыг судлан дипломны ажил бичих, судалгааны ажлын туршлага олох
Хугацаа	1-3 сар (6 сар хүртэл)			4-6 сар
Байршил	УБ хот	УБ хот, ОТ уурхайн талбар	УБ хот	УБ хот, ОТ уурхайн талбар (2-3 удаа)



Мэргэжлийн чиглэл болон оюутны тоо компанийн газар, хэлтсүүдийн захиалгын дагуу тодорхойлогдоно.



www.ot.mn

Хөтөлбөрийг нээлттэй зарлаж, дадлагажигч оюутан болон судалгааны багийг ярилцлагын, мөн бусад шаардлагатай сонгон шалгаруулалтын аргаар шалгаруулж авна.

Зарлагдах хугацаа:

5, 8, 12 сар

Өргөдөл гаргагчид тавигдах шаардлага:



- Монгол улсын иргэн байх;
- Магадлан итгэмжлэгдсэн их дээд сургуулийн 2, 3, 4-р дамжаа, өдрийн ангид суралцаж байх
- Голч дүн 3.2 ба түүнээс дээш байх
- Оюу толгой компанийн тэтгэлэгт оюутан, компанийн Ирээдүйн мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн оролцогч болон эмэгтэй оюутныг тус хөтөлбөрт хамрагдахаар өргөдөл гаргахыг тусгайлан урьж байна.

Үйлдвэрлэлийн судалгааны ажил



Үйлдвэрлэлийн судалгааны ажил

- Бодит асуудал судалж, шийдвэрлэх арга зам, хувилбар боловсруулах
- Оюутны мэдлэгийг дээшлүүлэх, асуудал шийдвэрлэх, багаар ажиллах, манлайлах зэрэг ирээдүйд шаардагдах чухал үр чадвараас эзэмшүүлэх
- Аюулгүй ажиллагааны соёл, ажлын гарааны эхлэл
- Их дээд сургууль, бизнесийн байгууллага хоорондын хамтын ажиллагааг тэлэх боломж

Сэдэв, шалгаруулалт

Байгууллагаас тодорхойлсон сэдвийн дагуу холбогдох чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа сургуулиудын дунд зарлаж, судалгааны багийг сонгон шалгаруулна.

Хамрах хүрээ

Төлөвлөсөн хугацаа болон төсөвт багтахын тулд хөтөлбөрөөс тодорхойлогдон гарах үр дүнгээр хязгаарлагдана.

Байршил

УБ хот, оюутнууд болон зөвлөхөөс бүрдсэн судалгааны баг уурхайн талбарт 2-3 удаа нэг өдрийн хугацаатай очно

Талуудын үүрэг, оролцоо

- Хөтөлбөрт оролцож буй компанийн хэлтсүүд нь үйлдвэрлэлийн асуудлыг сонгон, даалгавар болгож, хамтран ажиллах зөвлөх инженер, ажилтныг томилно.
- Их дээд сургууль нь тус хөтөлбөрт хамрагдах судалгааны багийг бүрдүүлэн зөвлөх багш нарыг томилно.
- Судалгааны багийн оюутнууд нэг хичээлийн улиралд сургуулийн зөвлөх багш болон компанийн зөвлөх инженерүүдтэй хамтран тухайн судалгааны ажлын сэдвийн хүрээнд ажиллан шийдэл, хувилбарыг болосруулах замаар дипломын ажлаа гүйцэтгэнэ.



Түгээмэл асуулт, хариулт



Асуулт	Хариулт
Хөтөлбөрт хэрхэн хамрагдах вэ, зарын мэдээлэл хаанаас авах вэ?	Оюу толгойд дадлагажуулах хөтөлбөрийг хэлтсүүдийн хүсэлт дээр үндэслэн холбогдох чиглэлүүдийг тодорхой зааж нэгдсэн журмаар нээлттэй зарлаж сонгон шалгаруулалт хийдэг. Хөтөлбөрийн зарыг www.ot.mn вэб хуудсанд нээлттэй зарлана.
Дадлагын хөтөлбөр нь олговортой байх уу?	Дадлагын хөтөлбөр нь олговоргүй байна. Компьютер, бичиг хэрэг болон бусад зайлшгүй шаардлагатай зүйлсийг компанийн зүгээс хангана. Уурхайн талбарт дадлага хийх дадлагажигчдад ажлын нэг ээлжийн хувцасыг олгоно. Улаанбаатар хот, уурхайн талбар хоорондын тээврийг компаний зүгээс зохицуулна.
Сонгон шалгаруулалтыг хэн, хэрхэн явуулдаг вэ?	<ul style="list-style-type: none">• Мэргэжлийн чиглэлийг компаний зүгээс тодорхойлж жил бүрийн 5,8,12 саруудад нээлттэй зарлана.• Үйлдвэрлэлийн судалгааны ажлыг компаниас тодорхойлсон сэдвийн хүрээнд холбогдох сургуулиудын дунд зарлана.• Сонгон шалгаруулалтыг Хүний нөөцийн хэлтэс, дадлагажигч сонгон шалгаруулж авах хэлтсээс бүрэлдэхүүнтэй явуулна.
Дадлагын явцад чөлөө авч болох уу? Чөлөө авах бол хэнд хандах вэ?	Болно. Чөлөө авах өдрөөс 14 хоногийн өмнө дадлагын удирдагчдаа урьдчилан мэдэгдэж чөлөөг авна. Хэрвээ яаралтай гэнэтийн шалтгаанаар чөлөө авах бол аль болох эр т мэдэгдэх шаардлагатай.
Дадлагын хугацаагаа сунгах боломжтой юу?	Хэрвээ хэлтсээс сунгах хүсэлт ирвэл нэг удаа сунгах боломжтой. Дадлагын төрлүүдээсээ хамаараан үргэлжлэх хугацаан нь өөр өөр байж болох ч нэг оюутны нийт дадлагын хугацаа 6-н сараас хэтрэхгүй байна.
Дадлагын тодорхой нэгдсэн хөтөлбөр, сургалт байх уу?	<ul style="list-style-type: none">• Дадлагын эхэнд дадлагын удирдагч таньтай дадлагын хугацаанд хийж гүйцэтгэх ажил болон сургалт хөгжлийн талаар ярилцан хөгжлийн төлөвлөгөөгөө гаргана.• Хөгжлийн төлөвлөгөөний гүйцэтгэл болон дадлагын үнэлгээг хөтөлбөрийн төгсгөлд дадлагажигч болон удирдагч хамтран хийнэ.
Дадлага хийснээр үндсэн ажлын байранд шилжин ажиллах боломж олдох уу?	Компанийн гадагшаа зарлагдсан ажлын байранд та бусад хүмүүсийн адил өргөдөл гаргах боломжтой. Тэрнээс шууд ажлын байранд шилжүүлэн авахгүй.

БАЯРЛАЛАА!



ot.mn



oyutolgoi



@OTMongolia



TsolmonTs@ot.mn